



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 19/287

Улаанбаатар хот

「 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоол, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.5.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилготой Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичгүүдийг үндэслэн, гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний уялдаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, хариуцах эзэн, хугацааг тодорхой тусган боловсруулж, 2019 оны 08 дугаар сарын 15-ны дотор Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Х.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

115050000903

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2019 оны 07 дүгээр сарын 08-ны
өдрийн 07/08 тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Жаргалсайхан

Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

М.Энхболд

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

Н.Раднаасэд

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Н.Золжаргал

Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний
нөөцийн мэргэжилтэн

Б.Адъяа

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

С.Ариунжаргал

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах
мэргэжилтэн

Ж.Сувданзаяа

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн
бичиг:

Ц.Цолмон

Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн